

**“УЛААНБААТАР БУК”ХК-ИЙН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ”-ЫН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2025 оны жилийн эцэс

“УЛААНБААТАР БУК”ХК-ИЙН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ”-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ				
№	Компанийн засаглалын үндсэн зарчим	Үнэлгээний асуулга	Хэрэгжилт	
			оноо	хувь
1	ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна	12	100
2	ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ	ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ	10	100
3	ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ	ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана	6	100
4	АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО	ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана	6	100
5	ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА	ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина	8	100
6	ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ	Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна	5	83.3
7	ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ	Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ	8	100
8	КОМПАНИЙН СОЁЛ	ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно	6	100
9	ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ	Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана	10	100
нийт үнэлгээ			71	98.11

Компанийн засаглалын үнэлгээний асуулга					
НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ					
ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна					
№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь/ %/
1	1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	ТУЗ-нь ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулсан ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн баталж, мөрдөж ажиллаж байна. /Компанийн сайтад/ ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд гишүүд ямар тохиолдолд хөндлөнгийн мэргэжлийн этгээдийн зөвлөгөөг компанийн зардлаар авч болох талаарх зохицуулалтыг нэмэлтээр оруулж ТУЗ-ийн шийдвэрээр баталгаажуулав.	Нэмэлт өөрчлөлтийн тухай ТУЗ-ийн тогтоолыг 2024-6-25-ны өдөр СЗХ-д цахимаар хүргүүлсэн.	2	100
2	1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.	ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын бичиг баримтыг шинэчлэн баталж, мөрдөж ажиллаж байна./Компанийн сайтад/	ТУЗ-ийн №2022/18 тогтоол	2	100
3	1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршилага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна.	ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршилага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, 2025 онд хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг Компанийн болон ТУЗ-ийн жилийн үйл ажиллагааны 2025 оны тайланд тусгасан. /ТУЗ-ийн 2025 оны жилийн эцсийн тайланд хавсралтаар тусгасан. /		2	100
4	1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршилагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.	Компанийн дүрэм, ТУЗ болон түүний дэргэдэх хороодын журамд тэдгээрийн бүтэц бүрэлдэхүүн, гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршилагад тавигдах шаардлага зэргийг тусгасан ба ТУЗ-ийн бүрэлдэхүүний аль нэг хүйсийн эзлэх хувийг гучаас доошгүй байх зорилтыг нэр дэвшүүлэх хорооны журамд шинээр тусган ТУЗ-ийн шийдвэрээр баталгаажуулав.	Журамд нэмэлт өөрчлөлтийг оруулж ТУЗ-өөр батлуулан мөрдөн ажиллаж байна.	2	100
5	1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.	ХЭХ-аар ТУЗ-ийн 8 гишүүнийг улираан, 1 гишүүнийг шинээр сонгож баталсан ба сонгогдсон гишүүд бүгд засаглалын сургалтад хамрагдсан болно. 2025 оны 10 сард “Дотоод аудит дахь ТУЗ-ийн манлайлал” сэдэвт сургалтыг “Компанийн засаглалын үндэсний зөвлөлтэй хамтран зохион байгуулсан. /УБ БҮК ХК сургалт.docx/	2025 оны 10 сард “Дотоод аудит дахь ТУЗ-ийн манлайлал” сэдэвт сургалтыг зохион байгуулсан	2	100
6	1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эрх үүрэг, хариуцлага зэргийг тодорхой тусгасан “ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журам”, ТУЗ-ийг төлөөлж ТУЗ-ийн даргатай байгуулсан гэрээний дагуу ТУЗ-ийн	СЗХ, МХБ-д хүргүүлэх мэдээ, тайланд ТУЗ-ийн зүгээс тогтмол	2	100

		нарийн бичгийн дарга үйл ажиллагаагаа явуулдаг ба эдгээр бичиг баримтад Нарийн бичгийн даргын хүлээх хариуцлагын талаар тодорхой тусгасан болно. /Компанийн сайтад/ /ТУЗ-ийн нарийн бичгийн даргын 2025 оны тайланг хавсаргасан/ ТУЗ-ийн нарийн бичгийн даргын тайлан 1.docx	хяналт тавьж ажиллаж байна.		
ДҮН				12	100
ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ					
7	2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	ТУЗ-ийн 6 гишүүн ердийн, 3-нь хараат бус гишүүнээр ажиллаж байгаа ба хороодын дарга нарыг Хараат бус гишүүдээр томилсон. ТУЗ-ийн дарга болон гишүүдийн олонхыг хараат бус болгох зорилтыг нэр дэвшүүлэх хорооны журамд тусгаж ТУЗ-ийн шийдвэрээр баталгаажуулав.	ТУЗ-ийн шийдвэрийг 2024-6-25-ны өдөр СЗХ-д цахим хаягаар хүргүүлсэн.	2	100
8	2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	Аудит, эрсдлийн хороо нь үйл ажиллагааны журам болон “Улаанбаатар БҮК”ХК-ийн санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын компанийг сонгон шалгаруулах, ажлын чанарыг хянах журам”-ыг батлан, үйл ажиллагаандаа мөрдөж ажилладаг. /Компанийн сайтад/ Аудит, эрсдлийн хорооны дарга нь хараат бус гишүүн /С.Б.Громов/ ба Аудит, эрсдлийн хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд тус хорооны хүсэлтээр оролцдог.	Журамд нэмэлт өөрчлөлтийг оруулсан ба ТУЗ баталсан.	2	100
9	2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.	Цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журамтай/Компанийн сайтад/ ба цалин урамшууллын бодлогын баримт бичгийг баталж 2022 оны 5 сарын 19-нд ТУЗ-ийн хуралд танилцуулсан. Цалин урамшууллын хорооны даргаар 2025 онд шинээр сонгогдсон хараат бус гишүүн Г.Ганболд ажиллахаар томилогдсон. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага хорооны хүсэлтээр оролцож байна.	Журамд нэмэлт өөрчлөлтийг оруулсан ба 2023 онд ТУЗ-ийн ээлжит хуралд оруулж батлуулсан болно.	2	100
10	2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	Нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журамтай ба залгамж халааны бодлогын баримт бичгийг шинэчлэн баталж, мөрдөж ажиллаж байна. /ТУЗ-ийн №2022/18 тогтоол / Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн ажиллаж байна. /Хорооны дарга хараат бус гишүүн Ч.Энхбат/	Компанийн сайтад байришуулсан	2	100
11	2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн	ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай		2	100

	дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй ажилладаг. /Хороодын тайлан хавсралад/ УЛААНБААТАР БУК хороодын тайлан 1.docx			
ДҮН				10	100
ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ					
ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана					
12	3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг шинэчлэн баталж/Компанийн сайтад/ хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллаж байна. МХБ-ийн сайтад хууль, журмын дагуу 5 багц мэдээллийг 11 төрлийн маягтын дагуу улирал, хагас жилээр байршуулан нийтэд мэдээлэх арга хэмжээ авч ажиллаж байна.	Журамд нэмэлт өөрчлөлтийг оруулж ТУЗ-өөр батлуулсан ба хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	2	100
13	3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг ТУЗ –нь Компанийнхаа цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэж ажилладаг.	Компанийн сайтад тухай бүр байршуулсан.	2	100
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, түүний тэнцвэртэй, тодорхой, бодит байдал, хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхэд жилд 2 удаа хөндлөнгийн аудитын байгууллагаар хяналтыг хийлгэж, /МХБ, Компанийн сайтад байршуулсан / өгсөн зөвлөмжийг тухай бүр ТУЗ-аар хэлэлцүүлэн Гүйцэтгэх удирдлагад тодорхой үүрэг даалгавар өгч хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг.	Хөндлөнгийн аудитын тайланг цаг хугацаанд нь хөрөнгийн биржийн сайтад байршуулсан	2	100
ДҮН				6	100
ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО					
ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана					
15	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Аудит, эрсдлийн хорооны үйл ажиллагааны журам болон “Улаанбаатар БУК” ХК-ийн санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын компанийг сонгон шалгаруулах, ажлын чанарыг хянах журам”-д хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтийг гэрээний үндсэн дээр хянаж ажилладаг. “Компанийн тухай хууль”-ийн 81.4.3 болон 76.1.10-д заасны дагуу 2025 оны санхүүгийн тайланд хараат бус аудит хийх Компаниар олон улсын эрхтэй “Пи Кэй Эф –Ай Эй Эс Аудит “ ХХК-ийг шинээр сонгож гэрээ байгуулан ажиллаж	Аудит, эрсдлийн хорооны шийдвэрийг хавсаргав.	2	100

		байна.2025 оны хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланд завсрын, жилийн эцсийн аудит хийсэн ба зөвлөмж дүгнэлтийг ТУЗ хэлэлцэж зохих арга хэмжээ авч ажиллаж байна.		
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгч ажилладаг.		2 100
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.	Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны хагас жилийн болон жилийн эцсийн тайланд тусгах ажлыг хэвшүүлэх талаар Дотоод аудитор, Дотоод хяналтын алба хамтран ажиллаж байна.	ТУЗ-ийн шийдвэрээр Аудит, эрсдлийн хороонд дотоод аудитор 5 дахь жилдээ ажиллаж байна.	2 100
ДҮН			6	100
ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА				
ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина				
18	5.1. Компани нь эрсдлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Компани эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд хяналт тавьж ажиллах зорилгоор ТУЗ – ийн шийдвэрээр 2022 онд ISO нэвтрүүлэх өргөн цар хүрээтэй ажлыг тодорхой хөтөлбөр, төлөвлөгөөтэйгээр эхлүүлж 2023 онд гэрчилгээ авсан ба 2024 онд 3 жилээр сунгаж үйл ажиллагааг үргэлжлүүлж байна. 2025 оны 10-11 сард “ЭС ЭФ СИ ЭС”ХХК магадлах аудитын үйл ажиллагааг амжилттай явуулсан.		2 100
19	5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.	ТУЗ 2023 онд Аудитын хороонд эрсдлийн хорооны чиг үүргийг хавсарган ажиллахаар зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Аудит эрсдлийн хорооны журам, Эрсдлийн удирдлагын бодлогыг ТУЗ баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Журмыг Компанийн сайтад байршуулсан.		2 100
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	1. "УБ БҮК " ХК нь 2026 онд “Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ”, “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”, “Газар төлөв байдлын тайлан”-г “Ланд овнер” ХХК-тай гэрээ байгуулан хийлгүүлж байна. 2. Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлыг		2 100

“Богдын өндөр сүрвэй” ХХК-аар хийлгүүлэн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

3. 2026 оны 03-р сард гүйцэтгэх захирлын “Гамигаас хамгаалах мэргэжлийн анги байгуулах” тухай тушаалын дагуу ангийг шинэчлэн байгуулан түүний дагуу сургалтуудыг зохион байгуулан ажиллаж байна.
4. Химийн ослоос урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ авах төлөвлөгөө, гамигийн эрсдлийн ерөнхий үнэлгээний тайланд 2025 онд шинэчилэн тодотгол хийж батлуулав.
5. Гал унтраах шуурхай картыг боловсруулан батлуулав.
6. Компани нь нийт ажилтны аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийг Ажлын байрны 1, 2,3-р шатны үзлэг хийх аргачлалаар зохион байгуулан ажиллаж байна.
7. Ноцтой эрсдэлийн удирдлагын хүрээнд эрсдэх боломжтой бүхий л ажлыг үнэлж, хяналтын арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажилладаг.
8. Аюултай тохиолдлыг судлан бүртгэх журмыг шинэчлэн батлуулж 2020 оноос хойших осолд дөхсөн тохиолдолуудаар мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна.
9. Нийт ажиллагсдын 2021-2022, 2024 оны “Интер Мед” нэгдсэн эмнэлэгт хийлгэсэн эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний дүн, ХАБЭМТөвд 2022 онд хийлгэсэн химийн бодистой харьцаж буй болон гагнуурын ажиллагсдын хордлогын шинжилгээний дүн зэрэг бүртгэл мэдээллийг цахимжуулан нэгдсэн сан үүсгэн холбогдох арга хэмжээ авч ажиллаж байна.
10. Нийт ажиллагсдын хөдөлмөрийн чадвар түр алдалтад судалгаа хийн ажиллаж байна.

21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Комплайнсын хяналтын заавар болон Эрсдэлийн удирдлагын бодлогыг Аудит, Эрсдэлийн Хороо боловсруулан, ТУЗ баталсан. Хэрэгжилтын үр дүн, хараат бус байдалд ТУЗ, Аудит Эрсдэлийн Хороо хяналт тавьж ажилладаг.	Компанийн сайтад мэдээллийг байршуулсан.	2	100
ДҮН				8	100
ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ					
Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна					
22	6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, төсвийг 2025-4-04-ний өдрийн хувьцаа эзэмшигчийн хурлаар хэлэлцэж баталсан./ХЭХ-ын тогтоол, МХБ болон Компанийн сайт/		2	100
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.	Цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг тусгасан цалин, урамшууллын бодлогын баримтыг Цалин хөлсний хороогоор 2022-4-29-ний өдөр оруулан хэлэлцсэн ба энэхүү бодлогын бичиг баримтын хүрээнд 2 журам боловсруулагдаад байна. 2023 онд “ТУЗ-ийн гишүүн, эрх бүхий албан тушаалтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам” баталж жил бүр үнэлгээг ТУЗ-өөр хэлэлцэн ажиллаж байна. 2025 оны үнэлгээг жилийн эцсийн тайлан гарсны дараа Нэр дэвшүүлэх хороо ТУЗ-ийн 2026 оны эхний хуралд танилцуулсан./хавсралтад Нэр дэвшүүлэх хорооны шийдвэр/ Нэр дэвшүүлэх хорооны шийдвэр.pdf		2	100
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	Гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг ТУЗ-тэй байгуулсан гэрээнд тусган ажиллаж байна.		1	50
ДҮН				5	100
ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ					
Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ					
25	7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	Компани нь оролцогч талуудын бүлэг, ангилал бүрээр тэдгээрт тохирсон харилцах, хамтран ажиллах стратеги, арга хэлбэр, журамтай ажиллаж байна. /Компанийн сайта-д/ ТУЗ болон Гүйцэтгэх удирдлага нь бодлогыг хэрэгжүүлэх төсөв хуваарилж, чадварлаг, мэдлэгтэй хүний нөөц болон оролцогч талуудаас санал авах, мэдээлэл бүрдүүлэх тогтолцоогоор хангаж оролцогч талуудтай байгуулах аливаа гэрээ хэлцлийг ТУЗ-өөс баталсан бодлогын хүрээнд байгуулж хэрэгжүүлж байна.		2	100

26	7.2.Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг “Ёс зүйн дүрэм”-дээ тусган ажиллаж байна.		2	100
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор чиг үүргийн дагуу үйл ажиллагаа эрхэлж буй алба, хэлтсээс тухай бүр мэдээ мэдээллийг авч цахим хуудасд байршуулан идэвхтэй ажиллуулж байна.		2	100
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх талаар дотоод журамдаа тусган мөрдөж ажиллаж байгаа ба сар бүр дундчаар 30-50 ажилтнуудын нийгмийн асуудлыг амаар болон бичгээр шийдвэрлэн ажилласан байна. 2025 онд Компани 271 ажилтнуудыг гэнэтийн ослын даатгалд хамруулан энэхүү үйл ажиллагаанд 17 сая 344,0 мянган төгрөг зарцуулсан.		2	100
ДҮН				8	100
НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ					
ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно					
29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор Компанийн үнэт зүйлс, алсын харааг жил бүрийн бизнес төлөвлөгөөнд тусгаж ажилладаг ба ТУЗ нь ёс зүйн дүрмийг ТУЗ-өөр 2023 онд батлуулан мөрдөн ажиллаж байна.	Мэдээллийг Компанийн сайт, МХБ-ийн сайтад байршуулсан тайлан хэсэгт тусгасан	2	100
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.	Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг арилгуулах зорилгоор ТУЗ-ийн дэргэдэх Аудит эрсдлийн хороонд дотоод аудитор ажиллаж, тухай бүр ТУЗ-ийг холбогдох мэдээллээр хангаж ажиллаж байна.		2	100
31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	ТУЗ-өөр батлах “Ёс зүйн дүрэм”-д авлигла, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулалтыг оруулж баталсан.		2	100
ДҮН				6	100
ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ					
Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана					
32	9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.	Компани үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, Компанийн засаглалын тайлан, ТУЗ-ийн тайлан, хороод, нарийн бичгийн үйл ажиллагааны тайлан, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх тайлан, мэдээллийг		2	100

		цахим хуудсаараа болон СЗХ,МХБ -д тухай бүр хүргэж ажиллаж байна.		
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	Компанийн хөрөнгө оруулагчид болох хувьцаа эзэмшигчидтэй брокер, диллерийн компаниудаар дамжуулан харьцдаг ба холбоо барих нөхцөлийг бүрдүүлж Эрх бүхий албан тушаалтнуудын цахим хаяг, утас зэргийг МХБ, Компанийн веб сайтад тогтмол нээлттэй байршуулж ажиллаж байна.	2	100
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	Компани хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байгаа ба мэдээлэл хүссэн хувьцаа эзэмшигч иргэнд биечлэн, утсаар, цахим хаягаар хандаж тухай бүр мэдээллийг өгч ажиллаж байна.	2	100
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь анхаарал хандуулан тодорхой мэдээллийг үндэслэлтэй өгөх, үйлдвэрийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцуулах зэрэг арга хэмжээ авч ажиллаж байна.	2	100
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Компани сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмыг баталж мөрдүүлж ажилладаг.	2	100
ДҮН			10	100
НЭГДСЭН ДҮН			71	98,1

-oOo-